



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/104

Хэрлэн сум

Б.Оюундарийн сургалтын төлбөрт  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" арвантавдугаар хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Зөгийн үүр" арга хэмжээний хүрээнд "Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Хэрлэн сумын иргэн Б.Оюундарийн сургалтын төлбөрт зориулж, 700,000 (долоон зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Зөгийн үүр" арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ